

**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2012 ОНЫ 2 ДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

УЛААНБААТАР ХОТ

2012.08.07

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

ДҮГНЭЛТ

ДААТГАЛЫН САЛБАРЫН 2012 ОНЫ 2 УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2012 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, 191 даатгалын салбар, 2180 даатгалын төлөөлөгч, 13 даатгалын зуучлагч компани, 9 даатгалын хохирол үнэлэгч компани, 13 актуарч, нийт 2426 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

(Хүснэгт-1)

**Даатгалын зах зээл дээрх тусгай
зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

Он	2008-II	2009-II	2010-II	2011-II	2012- II
Даатгагч	16	17	16	17	18
Даатгалын компанийн салбар	109	130	134	149	191
Даатгалын төлөөлөгч	816	1233	2006	1992	2180
Даатгалын зуучлагч	4	4	8	9	13
Даатгалын хохирол үнэлэгч			6	7	9
Даатгалын актуарч			10	12	15
Бүгд	945	1384	2180	2186	2426


Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 1.1 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд “Хаан даатгал” ХХК ердийн даатгал, “Нэйшнл эженси” ХХК, “Юу ай би” ХХК, “Изи инвестмент” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулахаар тус тус тусгай зөвшөөрөл авсан байна. /График-1/



1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2012 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 18 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 97.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.4 тэрбум төгрөг буюу 1.35 дахин өссөн байна. Мөн 2010 оны мөн үетэй харьцуулахад 52.3 тэрбум төгрөг буюу 2.15 дахин өссөн дүнтэй байна. (График-2)



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2011 оны 2 дугаар улиралд 61.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 85.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 11.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15.0 хувийг эзэлж байсан бол тайлант оны мөн үед эргэлтийн хөрөнгө 80.7 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 82.61 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.39 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 1.35 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс өсч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин буурсан байна. Үүнд эргэлтийн бус хөрөнгө дэх үндсэн хөрөнгийн өсөлт, хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгийн өсөлтүүд нөлөөлсөн. (Хүснэгт-2)

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

Үзүүлэлтүүд	2011-02 улирал		2012-02 улирал		/сая төгрөгөөр/ Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
	Эргэлтийн хөрөнгө	61,120.02	85.00	80,673.20	82.61	19,553.18
Эргэлтийн бус хөрөнгө	11,126.09	15.00	16,980.20	17.39	5,854.11	2.39
Нийт хөрөнгө	72,247.10	100.00	97,653.40	100.00	25,407.29	0.00

2012 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 54.81 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 27.93 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 14.48 хувийг дансны авлага, үлдэх 2.78 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 6.17 пунктээр, дансны авлага 5.47 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 1.6 пунктээр өсч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 13.26 пунктээр буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 19.5 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд үүнд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Хаан даатгал” ХХК, дүрмийн сангаа нэмэгдүүлсэн “Мөнх даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иудын мөнгөн хөрөнгө нөлөөлж байна.

(Хүснэгт-3)

Эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2011-02 улирал		2012-02 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41,603.70	68.07	44,219.70	54.81	2,616.00	(13.26)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	13,297.10	21.76	22,531.80	27.93	9,234.70	6.17
Дансны авлага	5,508.30	9.01	11,680.20	14.48	6,171.90	5.47
Бусад эргэлтийн хөрөнгө	711.10	1.16	2,241.50	2.78	1,530.40	1.62
Эргэлтийн хөрөнгийн дүн	61,120.20	100.00	80,673.20	100.00	19,553.00	-

2012 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харуулахад “Жонон даатгал” ХХК хамгийн бага буюу 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.6 хувийг эзэлж байна.

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 21.3 хувийг “Монгол даатгал” ХХК дангаараа бүрдүүлж байна.

(Хүснэгт-4)

/сая төгрөгөөр/


Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1 Ард даатгал ХХК	6,017.0	6.2
2 Бодь даатгал ХХК	9,090.9	9.3
3 Ган зам даатгал ХХК	2,186.3	2.2
4 Мандал женерал даатгал ХХК	6,319.4	6.5
5 Жонон даатгал ХХК	1,597.2	1.6
6 МИГ даатгал ХХК	7,567.4	7.7
7 Монгол даатгал ХХК	20,789.8	21.3
8 Гэр даатгал ХХК	1,746.2	1.8
9 Моннис даатгал ХХК	3,145.9	3.2
10 Мөнх даатгал ХХК	3,106.3	3.2
11 Номин даатгал ХХК	5,324.2	5.5

12	Нэйшнл лайф даатгал ХХК	3,640.6	3.7
13	Практикал даатгал ХХК	6,952.6	7.1
14	Тэнгэр даатгал ХХК	6,492.7	6.6
15	Соёмбо даатгал ХХК	6,738.5	6.9
16	Монре даатгал ХХК	2,589.2	2.7
17	Хаан даатгал ХХК	2,011.9	2.1
18	УБ хотын даатгал ХХК	2,337.3	2.4
Дүн		97,653.4	100.0

1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилээр хагас жилийн байдлаар харьцуулж харахад дараахь байдалтай байна.

(График-3)



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2010 оны 2 дугаар улиралд 59.6 хувийг эзэлж байсан бол 2011 оны мөн үед 47.0 хувь, тайлант үед 47.1 хувийг эзэлж өсөх хандлага ажиглагдаж байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2010 оноос 2011 оны хагас жил хүртэл өсч, улмаар тайлант үед 7.8 пунктээр буурсан байна. Харин өр төлбөрийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 0.8 пунктээр өссөн байна.

1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2012 оны 2 дугаар улиралд 41865.1 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.73 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 41522.2 сая төгрөг,

урт хугацааны даатгагч 342.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 17407.1 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 200.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 8602.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хэлбэрээр 2012 оны 2 дугаар улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөрөнгийн даатгал 4543.1 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 1930.1 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 1577.1 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 194.7 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 551.2 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 7536.7 сая төгрөгөөр, ачааны даатгал 167.5 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 20.4 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 24.6 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 11.4 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 370.3 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 537.1 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 144.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, мал амьтдын даатгал 0.6 сая төгрөгөөр буурсан байна.

(Хүснэгт-5)
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2011.06.30	2012.06.30	Өөрчлөлт +/-, /-/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.2. Хөрөнгийн даатгал	5730.8	10273.9	4543.1
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	6719.9	8650	1930.1
1.8. Агаарын хөлгийн даатгал	2724.8	4301.9	1577.1
1.10. Хариуцлагын даатгал	3498.1	3692.8	194.7
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2550.7	3101.9	551.2
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1756.3	9293	7536.7
1.11. Санхүүгийн даатгал	510.3	880.6	370.3
1.5. Барилга угсралтын даатгал	147.6	684.7	537.1
1.4. Ачааны даатгал	475.9	643.4	167.5
2.1. Хугацаат амьдралын даатгал	34.1	178.2	144.1
2.5. Эрүүл мэндийн даатгал	62.9	83.3	20.4
1.7. Мал амьтдын даатгал	0.6	0	-0.6
1.6. Газар тариалангийн даатгал	0	0	0.0
2.3. Хуримтлалын даатгал	38.9	63.5	24.6
2.4 Тэтгэврийн даатгал	6.5	17.9	11.4
ДҮН	24 257.4	41 865.1	17 607.7

1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны 2 дугаар улиралд нийт 6531.1 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс барилга угсралтын даатгал 1.3 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 5.8 сая төгрөгөөр, хөрөнгийн даатгал 78.4 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 67.0 сая төгрөгөөр буурч, эрүүл мэндийн даатгал 6.0 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 987.6 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 3.2 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 292.7 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 746.1 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 267.6 сая төгрөгөөр, ачааны даатгал 32.0 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 11.9 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 25.6 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 3.5 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

(Хүснэгт-6)
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2011.06.30	2012.06.30	Өөрчлөлт
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	580.4	502.0	-78.4
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	2 061.3	3 048.9	987.6
1.8. Агаарын хөлгийн даатгал	5.5	8.7	3.2
1.10. Хариуцлагын даатгал	185.2	118.2	-67.00
1.1. Гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал	560.6	853.3	292.70
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	449.7	1 195.8	746.10
1.11. Санхүүгийн даатгал	350.6	618.2	267.60
1.5. Барилга угсралтын даатгал	1.3		-1.30
1.4. Ачааны даатгал	58.7	90.7	32.00
2.1. Хугацаат амьдралын даатгал	11.9	23.8	11.9
2.5. Эрүүл мэндийн даатгал	30.0	36.0	6.0
1.7. Мал амьтдын даатгал	5.8	0.0	-5.80
1.6. Газар тариалангийн даатгал		0.0	0.00
2.3. Хуримтлалын даатгал	6.4	32.0	25.6
2.4. Тэтгэврийн даатгал		3.5	3.5
ДҮН	4 307.4	6531.1	2182.70

Тайлант оны мөн үеийн даатгагчийн нөхөн төлбөр 6.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 2.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2012 оны 2 дугаар улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 30.1 хувь болж өмнөх жилийн мөн үеийнхээс 1.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 31.9 хувьтай байна. (График-4)



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2012 оны 2 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 38.5 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна. (Хүснэгт-7)

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2011-02	2012-02	
1	Ард даатгал ХХК	39.8	29.0	-10.81
2	Бодь даатгал ХХК	23.7	29.5	5.83
3	Ган зам даатгал ХХК	8.1	4.0	-4.15
4	Мандал женерал даатгал ХХК	0.0	5.0	5.00
5	Жонон даатгал ХХК	32.4	0.0	-32.40
6	МИГ даатгал ХХК	12.6	33.6	20.96
7	Монгол даатгал ХХК	38.8	38.5	-0.23
8	Гэр даатгал ХХК	36.7	3.9	-32.81
9	Моннис даатгал ХХК	1.7	15.6	13.92
10	Мөнх даатгал ХХК	48.3	9.6	-38.74
11	Номин даатгал ХХК	45.7	31.6	-14.08
12	Нэйшнл лайф даатгал ХХК	14.9	27.8	12.88
13	Практикал даатгал ХХК	18.2	22.8	4.58
14	Тэнгэр даатгал ХХК	27.6	25.6	-2.05
15	Соёмбо даатгал ХХК	48.2	36.8	-11.46
16	Монре даатгал ХХК	24.6	19.7	-4.88
17	Хаан даатгал ХХК	0.0	0.0	0.00
18	УБ хотын даатгал ХХК	22	13.4	-8.57
	ДҮН	29.1	30.1	1.00

Даатгалын компаниудаас даатгуулагчдад олгосон даатгалын нөхөн олговрын түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Бодь даатгал” ХХК 5.83 пунктээр, “Миг даатгал”


ХХК 20.96 пунктээр, “Моннис даатгал” ХХК 13.92 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 12.88 пунктээр тус тус өсч, “Ард даатгал” ХХК 10.81 пунктээр, “Ганзам даатгал” ХХК 4.15 пунктээр, “Гэр даатгал” ХХК 32.81 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 38.74 пунктээр, “Номин даатгал” ХХК 14.08 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 11.46 пунктээр, “Монре даатгал” ХХК 4.88 пунктээр, “УБ хотын даатгал” ХХК тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2012 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3294.9 сая төгрөг болсон байна. Өмнөх жилийн мөн үеийнхээс 633.4 сая төгрөгөөр буурсан байна. (Хүснэгт-8)

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	217.2	6.6
2	Бодь даатгал ХХК	134.2	4.1
3	Ган зам даатгал ХХК	226.6	6.9
4	Мандал женерал даатгал ХХК	(60.2)	-1.8
5	Жонон даатгал ХХК	63.5	1.9
6	МИГ даатгал ХХК	544.4	16.5
7	Монгол даатгал ХХК	893.5	27.1
8	Гэр даатгал ХХК	13.8	0.4
9	Моннис даатгал ХХК	396.1	12.0
10	Мөнх даатгал ХХК	51.7	1.6
11	Номин даатгал ХХК	251.7	7.6
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(53.5)	-1.6
13	Практикал даатгал ХХК	122.1	3.7
14	Тэнгэр даатгал ХХК	457.6	13.9
15	Соёмбо даатгал ХХК	(69.9)	-2.1
16	Монре даатгал ХХК	88.2	2.7
17	Хаан даатгал ХХК	(10.6)	(0.32)
18	УБ хотын даатгал ХХК	28.5	0.9
	Ä-Í	3,294.9	100.0

Тайлант үеийн “Нэйшнл лайф даатгал” ХХК 53.5 сая төгрөг, “Мандал женерал даатгал” ХХК 60.2 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 69.9 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 10.6 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна. (График-5)




Даатгалын компаниудын хуримтлагдсан ашгийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулахад 10.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн эхний хагас байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2010 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц 26.9 тэрбум байсан бол тайлант оны мөн үед 46.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.36 дахин өссөн байна.

(График-6)



1.9 ДАВХАР ДААТГАЛ

2012 оны 2 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 11.2 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 5.9 тэрбум төгрөгөөр буюу 2.09 дахин өссөн дүнтэй гарсан байна.

(График-7)



(Хүснэгт-9)

(сая төгрөгөөр)

№	Компанийн нэр	2011-II		2012-II		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	208.8		986.8		778	
			3.84		8.77		4.93
2	Бодь даатгал	1989.5		3914.4		1924.9	
			36.61		34.80		(1.81)
3	Тэнгэр даатгал	259		188.5		-70.5	
			4.77		1.68		(3.09)
4	Практикал даатгал	28.3		68.8		40.5	
			0.52		0.61		0.09
5	Миг даатгал	919.2		1215.6		296.4	
			16.91		10.81		(6.11)
6	Монгол даатгал	279.9		3420.2		3140.3	
			5.15		30.40		25.25
7	Номин даатгал	11.4		6.9		-4.5	
			0.21		0.06		(0.15)
8	Нэйшнл лайф даатгал	40.6				-40.6	
			0.75		-		(0.75)
9	Монре даатгал	0		63.6		63.6	
			-		0.57		0.57
10	УБ даатгал	7.7				-7.7	
			0.14		-		(0.14)
11	Соёмбо даатгал	1056.5		28.2		-1028.3	
			19.44		0.25		(19.19)
12	УБ хотын даатгал	27				-27	
			0.50		-		(0.50)
13	Ган зам даатгал	69.6		170.5		100.9	
			1.28		1.52		0.23
14	Мандал женерал даатгал	0		334.2		334.2	
			-		2.97		
15	Моннис даатгал	537.3		852.1		314.8	

	9.89	7.57	(2.31)
5434.8	100	100	5815 -2.97072
11,249.80			

Гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2011 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 778.0 сая төгрөгөөр, “Бодь даатгал” ХХК 1924.9 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 296.4 сая төгрөгөөр, “Монгол даатгал” ХХК 3140.0 сая төгрөгөөр, “Ган зам даатгал” ХХК 100.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж бусад даатгагчийн хувьд бууруулсан байна.

2012 онд шинээр “Монре даатгал” ХХК, “Мандал женерал даатгал” ХХК-иуд өөрсдийн эрсдэлээ даатгуулахаар гадаадын давхар даатгагчид даатгуулсан нь давхар даатгалын хураамжийг өсөхөд нөлөөлсөн байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2012 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 17 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 191 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 42-оор нэмэгдсэн байна.

2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Тайлант үеийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 94.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 23.9 тэрбум төгрөгөөр буюу 1.34 дахин өссөн байна. График-10



2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос тогтвортой өссөн байна. (Хүснэгт-10)

/сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2011- 2-р улирал		2012 – 2-р улирал		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	20217.9	76.0	34653.1	81.0	14435.2	5.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6418.8	24.0	8208.6	19.0	1789.8	-5.0
Эзэмшигчдийн өмчийн дүн	26636.7	100.0	42861.7	100.0	16225.0	

Тайлант үеийн эзэмшигчийн өмч өмнөх оны мөн үеийнхээс 14435.2 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 1789.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 41522.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 11249.7 сая төгрөг буюу 27.0 хувийг давхар даатгалд, 235.2 сая төгрөг буюу 1.0 хувийг хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 30037.4 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2011 оны 2 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 25.1 хувь буюу 10440.9 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 17.3 хувь буюу 7176.2 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 42.4 хувийг эзэлсэн байна.

(Хүснэгт-11)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	4,004.1	9.6
2	Бодь даатгал ХХК	7,176.2	17.3
3	Ган зам даатгал ХХК	256.1	0.6
4	Мандал женерал даатгал ХХК	523.0	1.3
5	Жонон даатгал ХХК	59.4	0.1
6	МИГ даатгал ХХК	4,682.8	11.3
7	Монгол даатгал ХХК	10,440.9	25.1
8	Гэр даатгал ХХК	67.7	0.2
9	Моннис даатгал ХХК	1,355.3	3.3
10	Мөнх даатгал ХХК	498.7	1.2
11	Номин даатгал ХХК	2,551.0	6.1
12	Практикал даатгал ХХК	2,571.6	6.2
13	Тэнгэр даатгал ХХК	2,447.7	5.9
14	Соёмбо даатгал ХХК	3,057.4	7.4
15	Монре даатгал ХХК	1,313.7	3.2
16	Хаан даатгал ХХК	25.5	0.1

17	УБ хотын даатгал ХХК	491.2	1.2
	Дүн	41,522.3	100.0

2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны хагас жилийн байдлаар 6394.8 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 2136 сая төгрөгөөр нэмэгдсэн буюу 1.5 дахин өссөн байна.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 34.9 хувь, “Ард даатгал” ХХК 10.2 хувь, “Миг даатгал” ХХК 11.4 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 56.5 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-12)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	650.2	10.2
2	Бодь даатгал ХХК	605.8	9.5
3	Ган зам даатгал ХХК	9.6	0.2
4	Мандал женерал даатгал ХХК	15.1	0.2
5	Жонон даатгал ХХК	-	0.0
6	МИГ даатгал ХХК	726.9	11.4
7	Монгол даатгал ХХК	2,231.6	34.9
8	Гэр даатгал ХХК	0.5	0.0
9	Моннис даатгал ХХК	59.5	0.9
10	Мөнх даатгал ХХК	43.9	0.7
11	Номин даатгал ХХК	451.4	7.1
12	Практикал даатгал ХХК	365.3	5.7
13	Тэнгэр даатгал ХХК	516.4	8.1
14	Соёмбо даатгал ХХК	562.5	8.8
15	Монре даатгал ХХК	107.0	1.7
16	Хаан даатгал ХХК	-	0
17	УБ хотын даатгал ХХК	49.1	0.8
	Дүн	6,394.8	100.0

2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад Тайлант үеийн байдлаар “Миг даатгал” ХХК 33.6 хувь “Соёмбо даатгал” ХХК 36.8 хувь, “Монгол даатгал” ХХК 38.5 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-13)

/төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Орлогод тооцсон хураамж	Нөхөн төлбөр	Хувь
---	---------------------	-------------------------	--------------	------

1	Ард даатгал ХХК	2,240,187,697.33	650 172 358.4	29.0
2	Бодь даатгал ХХК	2,052,508,756.68	605 782 310.3	29.5
3	Ган зам даатгал ХХК	240,684,993.47	9 623 147.0	4.0
4	Мандал генерал даатгал ХХК	303,216,560.27	15 097 170.0	5.0
5	Жонон даатгал ХХК	95,718,448.63	0.0	0.0
6	МИГ даатгал ХХК	2,164,944,637.00	726 862 219.0	33.6
7	Монгол даатгал ХХК	5,790,143,584.55	2 231 594 109.7	38.5
8	Гэр даатгал ХХК	15,019,487.51	590 000.0	3.9
9	Моннис даатгал ХХК	380,043,944.51	59 457 558.0	15.6
10	Мөнх даатгал ХХК	457,888,453.00	43 877 090.0	9.6
11	Номин даатгал ХХК	1,426,433,286.65	451 400 761.0	31.6
12	Практикал даатгал ХХК	1,602,077,504.19	365 376 782.7	22.8
13	Тэнгэр даатгал ХХК	2,019,791,445.60	516 364 794.9	25.6
14	Соёмбо даатгал ХХК	1,529,556,241.00	562 497 984.0	36.8
15	Монре даатгал ХХК	543,165,916.67	107 004 939.0	19.7
16	Хаан даатгал ХХК	25,466,836.00	0.0	0.0
17	УБ хотын даатгал ХХК	365,296,573.05	49,074,570.00	13.4
	ДҮН	21,252,144,709.01	6,394,775,889.29	30.09003

2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

2012 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3348.4 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 893.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 26.7 хувийг эзэлж байгаа бөгөөд “Миг даатгал” ХХК 544.4 сая төгрөг буюу 16.3 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 457.6 сая төгрөг буюу 13.7 хувийг тус тус эзэлж, эдгээр компаниуд нийт зах зээлийн 56.7 хувийг эзэлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	217.2	6.5
2	Бодь даатгал ХХК	134.2	4.0
3	Ган зам даатгал ХХК	226.6	6.8
4	Мандал женерал даатгал ХХК	(60.2)	0
5	Жонон даатгал ХХК	63.5	1.9
6	МИГ даатгал ХХК	544.4	16.3
7	Монгол даатгал ХХК	893.5	26.7
8	Гэр даатгал ХХК	13.8	0.4
9	Моннис даатгал ХХК	396.1	11.8
10	Мөнх даатгал ХХК	51.7	1.5
11	Номин даатгал ХХК	251.7	7.5
12	Практикал даатгал ХХК	122.1	3.6
13	Тэнгэр даатгал ХХК	457.6	13.7
14	Соёмбо даатгал ХХК	(69.9)	-2.1
15	Монре даатгал ХХК	88.2	2.6
16	Хаан даатгал ХХК	(10.6)	0
17	УБ хотын даатгал ХХК	28.5	0.9
	Дүн	3,348.4	100.0

/сая төгрөгөөр/

2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2012 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 23.0 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 60.0 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 15.0 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сан, 2.0 хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна. (Хүснэгт-15)

/төгрөгөөр/

Нөөц сан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	18,527,060,471.88	24,245,109,264.31	15,477,208,207.04	27,294,961,529.15
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	5,820,306,768.31	3,554,407,724.46	2,642,898,089.89	6,731,816,402.88
Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	74,502,219.39	5,929,210,950.00	5,911,039,288.73	92,673,880.66

Учирч болзошгүй нөөц сан	8,646,920,163.15	2,269,744,075.97	255,253,367.19	10,661,410,871.93
Тусгайлсан нөөц сан	2,813,202,107.85	0.00	2,008,763,184.84	804,438,923.01
Дүн	35,881,991,730.58	35,998,472,014.74	26,295,162,137.69	45,585,301,607.63

2011 оны жилийн эцсийн байдлаар тусгайлсан нөөц санг хааж 2012 оны эхний үлдэгдэлгүй болгох талаар ердийн даатгалын компаниудад шаардлага өгсөнөөр 2.0 тэрбумыг хаасан байна. байна.

2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2012 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 11249.8 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 34.8 хувь, “Монгол даатгал” ХХК 30.4 хувь тус тус эзэлсэнээр нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 65.2 хувийг эзэлж байна. (Хүснэгт-16) /сая төгрөгөөр/

№	Компанийн нэр	2012-II	
		тоо	хувь
1	Ард даатгал ХХК	986.8	8.77
2	Бодь даатгал ХХК	3914.4	34.80
3	Тэнгэр даатгал ХХК	188.5	1.68
4	Практикал даатгал ХХК	68.8	0.61
5	Миг даатгал ХХК	1215.6	10.81
6	Монгол даатгал ХХК	3420.2	30.40
7	Номин даатгал ХХК	6.9	0.06
9	Монре даатгал ХХК	63.6	0.57
10	УБ даатгал ХХК		-
11	Соёмбо даатгал ХХК	28.2	0.25
12	УБ хотын даатгал ХХК		-
13	Ган зам даатгал ХХК	170.5	1.52
14	Мандал женерал даатгал ХХК	334.2	2.97
15	Моннис даатгал ХХК	852.1	7.57
	Дүн	11,249.80	100

ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 3640.6 сая төгрөгт хүрсэн байна. /График-11 /сая төгрөгөөр/



Тайланг хугацаанд гарсан хөрөнгийн өсөлт нь Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор тус компанийн дүрмийн сангийн хэмжээг 3.5 тэрбум болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой. Тус компанийн нийт хөрөнгө сүүлийн 3 жилийн хугацаанд 3.3 дахин нэмэгдсэн байна.

3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ, НӨХӨН ТӨЛБӨР

Урт хугацааны даатгалын компани 2012 оны 2 дугаар улирлын байдлаар 342.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 8.5 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 334.4 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 3 жилийн мөн үеийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт-17) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2010-2	2011-2	2012-2
Хураамжийн орлого	70.1	142.4	342.9
Давхар даатгал	26.1	40.6	8.5
Нөхөн төлбөр	14.0	21.2	95.2

3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 700.0 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 21.5 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-18) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2010-2	2011-2	2012-2
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-408.3	-594.4	-700.0
Тайланг үеийн цэвэр ашиг алдагдал	-74.4	-119.8	-53.5
Нөөц сан	49.7	138.1	428.7

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна.

(Хүснэгт-19)

/сая төгрөгөөр/

Даатгалын нөөц	2010-2	2011-2	2012-2
Хувь оролцоотой гэрээний нөөц сан			-
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	49.7	138.1	428.7
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан			-
ДҮН	49.7	138.1	428,7

Нөөц сан 2012 оны 2 дугаар улирлын байдлаар 428.7 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 290.0 сая төгрөгөөр буюу 3.1 дахин өссөн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 2 дугаар улиралд нийт 13 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 206.6 сая төгрөг болсон үүнээс 89.0 хувь буюу 184.7 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

(Хүснэгт-20)

/сая төгрөгөөр/

№	Зуучлагч компанийн нэр	2011.06.30	2012.06.30	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	16.8	33.7	16.9
2	“АМЕ” ХХК	6.9	2.5	-4.4
3	“Ачит ундарга” ХХК	27.2	45.6	18.4
4	“Лояалти солюшн” ХХК	24.3	34.9	10.6
5	“Эм Жи Ай Би” ХХК	7.6	0	-7.6
6	“Ренессанс групп” ХХК	20.6	33.8	13.2
7	“Жомолхари” ХХК	0	4.9	4.9
8	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	35.6	0	-35.6
9	“Юу ай би” ХХК	-	6.7	6.7
10	“Си эн эн икс” ХХК	-	0	
11	“Изи инвестмэнт” ХХК	-	0	
12	“Гэрэлт буян ундрах” ХХК	-	0	
13	“Нэйшнл эженси” ХХК	-	44.4	44.4
	Нийт дүн	139.1	206.6	67.5

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Лоялти солюшн” ХХК 10.6 сая төгрөгөөр, “Ачит ундарга” ХХК 18.4 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 13.2 сая төгрөгөөр, “Жомолхари” ХХК 4.9 сая төгрөгөөр, “Асимон брокерс” ХХК 16.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 35.6 сая төгрөгөөр төгрөгөөр, Аме” ХХК 4.4 сая төгрөгөөр, “Эм жи ай би” ХХК 7.6 сая төгрөгөөр тус тус буурсан.

“Нэйшнл эженси” ХХК, “Ачит ундарга” ХХК-иудын даатгалын зуучлалын орлого нь нийт орлоын 43.5 хувийг эзэлсэн байна.

4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 81.5 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 51.0 хувь буюу 41.8 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 48.0 хувийг бусад орлого эзэлж байна.

(Хүснэгт-21)

/сая төгрөгөөр/

Үнэлэгч компанийн нэр	2011.06.30	2012.06.30	Өсөлт бууралт
1 “Бест эстимэйт” ХХК	3.1	5.7	2.6
2 “Гэрэгэ эстимэйт” ХХК	12.6	32.4	19.8
3 “Файн эстимэйт” ХХК	0	0	0
4 “Итгэлт эстимэйт” ХХК	49.3	0	-49.3
5 “Мега марз” ХХК	0	0	0
6 “Вендо” ХХК	2.2	10.3	8.1
7 “Жи ай си си” ХХК	-	5.3	5.3
8 “Арвижих эстимэйт” ХХК	0	9.5	9.5
9 “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	11.2	18.3	7.1
Нийт дүн	78.5	81.5	

2011 оны тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Гэрэгэ эстимэйт” ХХК 8.9 сая төгрөгөөр, “Вендо” ХХК 5.5 сая төгрөгөөр тус тус өсч, бусад хохирол үнэлэгч компаниудын даатгалын хохирол үнэлгээний орлого буурсан байна.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК даатгалын хохирол үнэлгээний орлогыг төвлөрүүлж ажиллаагүй бөгөөд “Итгэлт эстимэйт” нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байсан байна.

ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо сүүлийн хоёр жилд эрс нэмэгдэх хандлагатай болсон байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад 1.35 дахин өсч 97.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант үеийн цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин буурсан байна. Энэ нь алдагдалтай ажилласан компаниуд тайлант үеийн ашгийг бууруулахад нөлөөлсөн.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 17.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарсан нь нэг талаас зах зээлийн хамралт нэмэгдсэн, нөгөө талаас үнийн ерөнхий өсөлттэй холбоотой байна.

Даатгалын зах зээлийн дийлэнх үзүүлэлтүүд эерэг хандлагатай, өсөлттэй гарсан хэдий ч дараахь асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна.

1. Монгол Улсад даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагчид шууд даатгуулах явдал их гарч байна. Энэ нь манай дотоодын даатгагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөс гадна Монгол Улсад татвар төлөхгүй байх нөхцөлийг бүрдэж байна.

2. Даатгалын компаниудын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөнд нөөц сангийн эзлэх хувь хэмжээ сүүлийн 3 жил дараалан байнга буурсаар ирсэн нь даатгалын компанийн эрсдэл даах чадавхид сөргөөр нөлөөлөхөөр байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС